



## БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

### ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТАД ХИЙСЭН НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН



*Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг хууль,  
журмын дагуу зарцуулаагүй байна.*

## АГУУЛГА

Тайланг бэлтгэсэн:

Баянхонгор аймаг дахь  
Төрийн аудитын газар

Газрын дарга, тэргүүлэх  
аудитор

Б.Мөнхбат

Аудитын менежер

Д.Цэцэгмаа

Ахлах шинжээч Ё.Сугаррагчаа

Аудитор Б.Должмаа

П.Мөнх-Эрдэнэ

2017 оны 04 дүгээр сар

Үг тайланг Баянхонгор аймаг  
дахь Төрийн аудитын газрын  
Цахим хуудаснаас үзнэ үү:

[www.audit.bayankhongor.mn](http://www.audit.bayankhongor.mn)

Аудитын тайлан, дүгнэлттэй  
холбоотой асуудлаар нэмж  
тодруулах, асууж лавлах зүйл  
байвал 70442584, 70442424  
дугаарын утсаар харилцана уу.

**Хаяг:** Баянхонгор сум, Номгон  
1-р баг, Төр захирагааны ордон  
3-р давхар

|  |       |
|--|-------|
| Товчилсон үгийн жагсаалт .....   | 1     |
| Адуит хийх үндэслэл, зорилт, хамарсан хүрээ, арга зүй.....   | 2     |
| Аудитад ашигласан хууль тогтоомж, шалгуур үзүүлэлт.....  | 2     |
| Үндсэн мэдээлэл.....   | 3     |
| Аудит хийсэн багийн бүрэлдэхүүн.....   | 3     |
| Аудитын хугацаа.....   | 3     |
| <br>   |       |
| Бүлэг 1. ОНХС-ийн хөрөнгийг хууль, журамд заасны дагуу<br>төлөвлөж хуваарилсан байна.....  | 4-7   |
| <br>   |       |
| Бүлэг 2. Иргэдээр дэмжигдээгүй болон ТЭЗҮ, зураг<br>төсөвгүй төсөл, арга хэмжээг баталсан, зарим ажилд<br>худалдан авах ажиллагааны журмыг зөрчиж шууд гэрээ<br>байгуулж хэрэгжүүлжээ..... | 8-15  |
| <br>   |       |
| Бүлэг 3. Сумдын ИТХ ОНХС-ийн зарцуулалтад хяналт тавих<br>үүрэг бүхий Хяналтын хороог байгуулаагүй, ОНХС-гийн<br>хэрэгжилтийн тайланг аймгийн ЗДТГ-т ирүүлээгүй<br>байна.....              | 16-18 |
| <br>   |       |
| Дүгнэлт .....  | 19    |
| <br>   |       |
| Зөвлөмж.....   | 20-21 |

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

|               |   |
|---------------|---|
| УАГ           | Үндэсний аудитын газар  |
| НАГ           | Нийцлийн аудитын газар  |
| НА            | Нийцлийн аудит  |
| АДБОУС        | Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт   |
| УИХ           | Улсын Их хурал  |
| ИТХ           | Иргэдийн төлөөлөгчдийн хурал  |
| ЗДТГ          | Засаг даргын тамгын газар   |
| СХАА          | Санхүүгийн хяналт, аудитын алба   |
| ОНХНС         | Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан   |
| ОНХС          | Орон нутгийн хөгжлийн сан   |
| ТБОНӨХБАҮХАТХ | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль |
| ХОХБТХ        | Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс                                      |
| ЖДҮ           | Жижиг дунд үйлдвэрлэл   |
| БИНХ          | Багийн иргэдийн нийтийн хурал   |
| СТСХ          | Санхүү, төрийн сангийн хэлтэс   |
| ТЕЗ           | Төсвийн ерөнхийлөн захирагч   |
| ШШГА          | Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба  |
| ТЭЗҮ          | Техник эдийн засгийн үндэслэл   |

## НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

### Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын мэдэгдэл

#### 1. Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Аудитыг Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2017 оны "Аудитын сэдэв батлах тухай" 02 дугаар тогтоол, УАГ-ын 2017 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1-д тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд гүйцэтгэв.

#### 2. Аудитын зорилт

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн 2016 оны төлөвлөлт, бүрдүүлэлт, хуваарилалт, зарцуулалт нь хууль тогтоомжид нийцсэн эсэхэд аудит хийж, дүгнэлт, зөвлөмж боловсруулан дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдэв. Энэ зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг хийж гүйцэтгэв.

- ОНХС-ийн хөрөнгийн эх үүсвэрийг хууль, журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлж, хаваарилсан уу?
- ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг хууль журамд заасны дагуу төлөвлөж, гүйцэтгэсэн үү?
- ОНХС-ийн зарцуулалтад тавих хяналтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, хэрэгжилтийг зааврын дагуу тайлагнасан уу?

#### 3. Аудитын хамарсан хүрээ

Аудитад аймаг, сумын ИТХ, ЗДТГ, СТСХ, багийн ИНХ, аймгийн ОНХС болон 20 сумын ОНХС-ийн хөрөнгийн 2016 оны төлөвлөлт, бүрдүүлэлт, хуваарилалт, зарцуулалт, санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээг хамруулан шалгав.

#### 4. Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэхдээ Төрийн хяналт, шалгалтын стандарт, түүнийг хэрэгжүүлэх аргачилсан зөвлөмж, нийцлийн аудитын гарын авлага Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт 4000-4200-г баримтлан, аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага, асуулга хийх, судалгаа гаргуулах, дүн, шинжилгээ хийх зэргээр аудитын горимын дагуу нотлох зүйл цуглувалж, аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

#### 5. Аудитад ашигласан хууль тогтоомж, шалгуур үзүүлэлтүүд

Дараах хууль эрхийн актууд болон шаардлагатай бусад баримт бичгийг аудитын шалгуур үзүүлэлт болгон ашиглав. Үүнд:

Төрийн аудитын тухай хууль, Төсвийн тухай хууль, 2016 оны төсвийн тухай хууль болон хуульд орсон нэмэлт өөрчлөлт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Засгийн газрын 2012 оны 30 дугаар тогтоол, Сангийн сайдын 2012 оны 244, 2014 оны 43 болон 212 дугаар тушаал, ТБОНӨХБАУХАТ хууль, Барилгын тухай хууль, Шилэн дансны тухай хууль, АДБОУС 100-400, 4100 болон дээрх хуулиудтай нийцүүлэн гаргасан дүрэм, журам, бусад эрх зүйн актуудыг ашиглав.

### **Үндсэн мэдээлэл**

Монгол Улсын Төсвийн тухай хуульд “Орон нутгийн хөгжлийн сан гэж орон нутгийн хөгжлийг дэмжих, бүс нутгийн тогтвортой байдлыг хангах зорилгоор улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгохоор дахин хуваарилалт хийх хөрөнгийг хэлнэ” гэж заасан байна.

Баянхонгор аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн өмнөх оны үлдэгдэл 433,5 сая байсан бөгөөд 2016 онд ОНХС-гаас орлогын шилжүүлгээр 4737,8 сая, бусад орлогоор 1328,3 сая, нийт 6499.6 сая төгрөг төвлөрсөн байна.

Аймаг, сумын ИТХ-аар ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх нийт 332 хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд 6500.5 сая төгрөг батлагдсанаас өмнөх оноос шилжиж ирсэн 66 ажилд 3104.7 сая, тухайн онд хэрэгжих 266 төсөл, арга хэмжээнд 3395.8 сая төгрөгийг зарцуулахаар хуваарилжээ.

Засгийн газрын 2013 оны 30 дугаар тогтоолоор орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон орон нутгийн хөгжлийн сангаас олгох шилжүүлэг тооцох аргачлалыг батлан мөрдөж байна.

### **Аудит хийсэн багийн бүрэлдэхүүн**

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Б.Мөнхбат удирдан аудитын менежер Д.Цэцэгмаа аудитын үе шат бүрт хяналт тавьж, ахлах шинжээч Ё.Сугаррагчаа, аудитор Б.Должмаа, П.Мөнх-Эрдэнэ нар гүйцэтгэв.

### **Аудитын хугацаа**

Сумын төсвийн ерөнхийлөн захирагчийн 2016 оны санхүүгийн тайлангийн аудит хийхдээ ОНХС-ийн судалгааг гаргуулан авч, объект дээрх ажлыг 2017 оны 04 дүгээр сарын 05-ний өдөр эхэлж, 04 дүгээр сарын 16-ны өдөр дуусгаж, аудитын тайланг мөн сарын 26-ны өдөр аймгийн Төрийн аудитын газрын удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, 2017 оны 4 дүгээр сарын 27-нд ҮАГ-ын Нийцлийн аудитын газар хүргүүлэв.

## НИЙЦЛИЙН АУДИТЫН ДҮН

**ОНХС-гийн хөрөнгийн эх үүсвэрийг хууль, журамд заасны дагуу төлөвлөж хуваарилсан байна.**

**Бүлэг 1. ОНХС-ийн хөрөнгийг хууль, журамд заасны дагуу төлөвлөж хуваарилсан байна.**

1.1.ОНХС-гаас 2016 онд тус аймагт олгохоор батлагдсан орлогын шилжүүлгийг Төсвийн тухай хуулийн 59.3-т заасан итгэлцүүрийг үндэслэн батлагдсан аргачлалын дагуу тооцож төлөвлөсөн байна.

Төсвийн тухай хуулийн 59.3<sup>1</sup> дахь дэх заалт, Сангийн сайдын 2012 оны 244-р тушаалаар батлагдсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах” журмын 6.1<sup>2</sup> дэх заалт, Засгийн газрын 30 дугаар тогтоолоор баталсан аргачлалын дагуу Монгол улсын 2016 оны Төсвийн тухай хуулиар ОНХС-аас 5681,9 сая төгрөгийн шилжүүлэг олгохоор батлагдсан байна.

УИХ-аар төсөвт тодотгол хийж, 2016.09.09-ний өдрийн Төсвийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлтөөр ОНХС-аас аймагт олгох шилжүүлгийг 944,1 сая төгрөгөөр бууруулан 4737,8 сая төгрөгөөр баталжээ.

Аймгийн ИТХ-ын 2016.10.11-ний өдрийн хуралдааны 3/4 тоот тогтоолоор орон нутгийн хөгжлийн индекс, хүн амын тоо, хүн амын нягтрал, алслалт, нутаг дэвсгэрийн хэмжээ, орон нутгийн татварын идэвх санаачилгын индекст үндэслэн хувь, итгэлцүүрийг харгалзан сум бүрээр тооцож, Төсвийн тухай хуулийн 59.2-т зааснаар аймагт олгох шилжүүлгийн 60-аас доошгүй хувь буюу 2842,7 сая төгрөгийг сумдад, 40 хувь буюу 1895,1 сая төгрөгийг аймгийн ОНХС-д олгохоор баталсан байна. 2016 онд сумдын ОНХС-д олгохоор тооцсон орлогын шилжүүлгийг сум тус бүрээр харуулбал:

<sup>1</sup> “Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас тухайн жил орон нутгийн төсөвт олгох шилжүүлгийг тодорхойлоходоо дараах итгэлцүүрийг үндэслэн тогтооно”

<sup>2</sup> “Аймаг, нийслэлийн Засаг дарга орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон орон нутгийн хөгжлийн сангаас олгох шилжүүлэг тооцох аргачлалыг ашиглан тухайн шатны орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрийг дараах байдлаар тооцож төлөвлөнө”

/сая.төг/

| Сумын нэр          | Орон нутгийн хөгжлийн индексээс хамааруулан олгох дүн | Хүн амын тооноос хамааруулан олгох дүн | Хүн амын нягтрал, алслалт, нутаг, дэвсгэрийн хэмжээнээс хамааруулан олгох дүн | Татварын идэвхи санаачлагаас хамааруулан олгох дүн | Итгэлцүүрт үндэслэсэн хуваарилалт ын дүн |
|--------------------|---|--|---|--|--|
| <b>Баянхонгор</b>  | 49.43   | 250.30                                 | 0.143   | 40.310   | <b>340.2</b>                             |
| <b>Баацагаан</b>   | 31.40   | 26.80                                  | 39.109  | 26.725   | <b>124.0</b>                             |
| <b>Баянбулаг</b>   | 38.61   | 14.30                                  | 38.163  | 40.476   | <b>131.5</b>                             |
| <b>Баянговь</b>    | 31.47   | 23.79                                  | 36.919  | 37.637   | <b>129.8</b>                             |
| <b>Баянлиг</b>     | 38.72   | 31.12                                  | 58.798  | 34.520   | <b>163.2</b>                             |
| <b>Баян-Овоо</b>   | 30.59   | 20.95                                  | 15.735  | 26.458   | <b>93.7</b>                              |
| <b>Баян-Өндөр</b>  | 44.73   | 21.68                                  | 91.755  | 29.372   | <b>187.5</b>                             |
| <b>Баянцагаан</b>  | 30.29   | 29.00                                  | 38.183  | 27.251   | <b>124.7</b>                             |
| <b>Богд</b>        | 34.17   | 25.60                                  | 24.840  | 39.840   | <b>124.5</b>                             |
| <b>Бөмбөгөр</b>    | 29.68   | 25.83                                  | 19.611  | 40.560   | <b>115.7</b>                             |
| <b>Бууцагаан</b>   | 35.77   | 30.64                                  | 34.826  | 40.496   | <b>141.7</b>                             |
| <b>Галуут</b>      | 26.30   | 32.71                                  | 23.713  | 27.854   | <b>110.6</b>                             |
| <b>Гурванбулаг</b> | 37.56   | 18.14                                  | 38.835  | 40.067   | <b>134.6</b>                             |
| <b>Жаргалант</b>   | 36.43   | 23.77                                  | 28.950  | 40.493   | <b>129.6</b>                             |
| <b>Жинст</b>       | 32.33   | 17.87                                  | 31.957  | 40.328   | <b>122.5</b>                             |
| <b>Заг</b>         | 42.10   | 17.17                                  | 26.342  | 40.400   | <b>126.0</b>                             |
| <b>Өлзийт</b>      | 32.14   | 30.82                                  | 15.039  | 25.056   | <b>103.0</b>                             |
| <b>Хүрээмжарал</b> | 36.14   | 14.82                                  | 39.808  | 40.214   | <b>131.0</b>                             |
| <b>Шинэжинст</b>   | 39.23   | 19.61                                  | 91.958  | 32.057   | <b>182.9</b>                             |
| <b>Эрдэнэцогт</b>  | 33.59   | 35.74                                  | 15.988  | 40.560   | <b>125.9</b>                             |
| <b>НИЙТ ДҮН</b>    | <b>710.67</b>   | <b>710.67</b>                          | <b>710.672</b>  | <b>710.67</b>                                      | <b>2,842.7</b>                           |

1.2. ОНХС-ийн эх үүсвэрийг төлөвлөхдөө Сангийн сайдын баталсан журамд заасан нэр төрлөөр тооцож төлөвлөсөн байна.

Аймаг, сумын ОНХС-ийн эх үүсвэрийг төлөвлөхдөө Сангийн сайдын 2012 оны 244 тоот тушаалаар батлагдсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын 6.1.1-д заасан эх үүсвэрээр тооцож, аймгийн ИТХ-ын 2016.10.11-ний өдрийн 3/4 тоот хуралдааны тогтоолоор ОНХСангаас 4737,8 сая төгрөгийн орлогын шилжүүлэг авахаар төлөвлөж баталсан байна.


Баянхонгор аймгийн хувьд улсын төсвөөс санхүүгийн дэмжлэг авдаг тул үндсэн тэнцлийн ашиг тооцогдохгүй. Аймаг, сумын ОНХС-д татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх замаар бий болсон эх үүсвэр, зардлыг хэмнэж бий болгосон эх үүсвэрээс орлого оруулахаар тооцож төлөвлөгдөөгүй ба урьд оны эхний үлдэгдэлээс 319,4 сая төгрөгийг төлөвлөж, оны дундуур орон нутгийн орлогоор 450,6 сая, ЖДҮ-ийг дэмжих зээлийн эргэн төлөлтөөр 250,0 сая, хандив тусламж

болон бусад орлогоор 720,5 сая, малжуулах төслийн эргэн төлөлтөөр 22,2 сая төгрөгөөр тодотгож, нийт 6500,5 сая төгрөгийн эх үүсвэрийг төлөвлөжээ.

2015 оны эцэст ОНХС-ийн дансанд 433,5 сая төгрөгийн үлдэгдэлтэй байсан бөгөөд үүнээс сумдууд 319,4 сая төгрөгийг тайлант онд зарцуулахаар төлөвлөж баталсан бөгөөд хуваарилаагүй 114,1 сая төгрөг оны эцэст зарцуулагдаагүй үлдэгдлээр байна.

**1.3. ОНХС-ийн эх үүсвэрийг хууль журамд заасан нэр төрлөөр бүрдүүлсэн байна.**

2016 онд аймаг, сумын ОНХС-д орлогын шилжүүлгээр 4737,8 сая, эхний үлдэгдэл 433,5 сая, өвс тэжээл болон малжуулах төслийн эргэн төлөлтөөс 53,3 сая, ЖДҮ-ийг дэмжих зориулалтаар өмнөх онуудад олгосон зээлийн эргэн төлөлтөөс 234,3 сая, хандив тусlamжийн болон бусад орлогоор 1040,7 сая, нийт 6499,6 сая төгрөг буюу 99,9 хувиар төвлөрүүлж бүрдүүлсэн байна.



Баянхонгор сум 2016 онд ОНХС-ийн хөрөнгөөр 6.5 тн үрийн төмсийг 1кг-ийг 700 төгрөгөөр тооцож, иргэдэд 4225,9 мянга, сумын ЗДТГ-ын ажиллагсадад 350,0 мянга, нийт 4575,9 мянган төгрөгийг гэрээ байгуулан зээлээр олгожээ. Үрийн төмсний үнэнд 2016 онд 1365,2 мянга, 2017 онд 107,1 мянган төгрөгийг харилцах дансанд төвлөрүүлсэн тул төлөгдөөгүй 3103,6 мянган төгрөгийг төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

Сангийн яамны төсвийн хяналт, эрсдэлийн удирдлагын газраас 2015.09.18-ны өдөр хийсэн санхүүгийн хяналт шалгалтаар гэрээний дагуу Скейл

ХХК-иас авах 195,0 сая төгрөгийн авлагыг тайланд бүрэн тусгах зөвлөмжийн дагуу 2015 оны аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд тусгасан хэдий ч авлагыг барагдуулах тал дээр тодорхой арга хэмжээ авч ажиллаагүй байсан тул 2016 оны ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар дээрх авлагыг 2017.08.01-ний дотор барагдуулах зөвлөмж өгөгдсөн байна.

ОНХС-гийн хөрөнгөөр жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх чиглэлээр Төсвийн тухай хуулийн 60.3.5<sup>3</sup> дахь заалтыг зөрчиж 2012-2015 онуудад олгосон зээлээс 2016.01.01-ний байдлаар 780,3 сая төгрөгийн үлдэгдэлтэй байсан ба 2016 онд зээлийн эргэн төлөлтөөр 241,0 сая, 2017 онд 5,8 сая, нийт 246,8 сая төгрөг төвлөрсөн нь өмнөх оны нийцлийн аудитаар өгсөн акт, зөвлөмжийн үр дүн гарсан байна. 2015 оноос хойш шинээр зээл олгоогүй, одоогоор зээлийн үлдэгдэл 533,5 сая төгрөг байгаагийн 88,0 хувь буюу 469,7 сая төгрөгийн зээл албадан гүйцэтгүүлэхээр аймгийн ШШГА-нд шилжиж, барьцаа хөрөнгө дээр үнэлгээ тогтоох, эрэн сурвалжлах, албадан төлүүлэх зэрэг ажлууд хийгдэж байна.

Аймгийн Засаг даргын А/683 тоот захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг зээлийн эргэн төлөлтөнд хяналт тавин ажиллаж байгаа ба авлагыг барагдуулах чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнг улирал бүр тооцож, аймгийн Засаг даргын зөвлөлд танилцуулж, үр дүнг тооцож ажиллах зөвлөмжийг хүргүүлэв.

**1.4. ОНХС-гаас 2016 онд аймагт олгосон шилжүүлгийг холбогдох хууль, журмын дагуу сумдад хуваарилж, батлагдсан хуваариар санхүүжүүлжээ.**

2016 оны Төсвийн тухай хуулиар тус аймгийн ОНХС-д 4737,8 сая төгрөгийн шилжүүлэг олгохоор батлагдсаныг бүрэн авчээ.

Аймгийн ИТХ-ын ээлжит хуралдаанаар ОНХС-ийн 4737,8 сая төгрөгийн орлогын шилжүүлгийн 40 хувь буюу 1895,1 сая төгрөгийг аймгийн ОНХСанд, 60 хувь буюу 2842,7 сая төгрөгийг 20 суманд олгохоор хуваарилсан байна.

Сумдад олгох орлогын шилжүүлгийн тооцооллыг хөгжлийн индекс, хүн амын тоо, нягтрал, алслалт, орон нутгийн татварын идэвх санаачилага зэрэг үзүүлэлтээр тооцож, Баянхонгор сумд хамгийн их 340,2 сая, хөдөөгийн сумдаас Баян-Өндөр сумд хамгийн их 187,5 сая, Баян-Овоо сумд хамгийн бага 93,7 сая төгрөг олгохоор тооцооллыг хийж, батлагдсан хуваарийн дагуу санхүүжүүлжээ.

<sup>3</sup> “ОНХС-аас зээл олгох, санхүүгийн үр дагавар бүхий баталгаа гаргах, хохирлыг нөхөн төлөх үүрэг авахыг хориглоно”

ОНХС-гийн хөрөнгийн эх үүсвэрийг хууль, журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлж, хуваарилсан уу?

**Бүлэг 2. Иргэдээр дэмжигдээгүй болон ТЭЗҮ, зураг төсөвгүй төсөл, арга хэмжээг баталсан, зарим ажилд худалдан авах ажиллагааны журмыг зөрчиж шууд гэрээ байгуулж хэрэгжүүлжээ.**

2.1. Баян-Овоо, Бөмбөгөр, Бууцагаан, Гурванбулаг сумаас бусад сум урьдчилсан саналын жагсаалтыг бэлтгэж, орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдуулж ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх төсөл, арга хэмжээг төлөвлөсөн байна.

Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалын 3 дугаар зүйлийн 3.5<sup>4</sup>-д заасны дагуу аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр нийт 36 арга хэмжээнд 2993,1 сая төгрөгийг зарцуулахаар баталсан нь “Баянхонгор аймгийг 2016-2025 онд хөгжүүлэх хөгжлийн бодлого”-ын баримт бичигтэй уялдаж төлөвлөгдсөн байна.

Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 4.1<sup>5</sup>-т заасны дагуу сумдууд Мерси Кори Олон улсын байгууллага, USAID төслийн хамтран боловсруулсан 2014-2026 оны хөгжлийн стратеги төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдуулж ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөсөн байна.

Харин Баян-Овоо, Бөмбөгөр, Бууцагаан, Гурванбулаг сум орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлээ тодорхойлоогүй нь “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 3.5, 5.7<sup>6</sup>, дахь заалттай нийцэхгүй байна.

2.2. ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх ажлыг хэлэлцэх багийн ИНХ-д иргэдийн оролцоо хангалтгүй, зарим сум иргэдийн саналд тусгагдаагүй төсөл арга хэмжээг баталж хэрэгжүүлсэн байна.

<sup>4</sup> “ЗДТГ нь ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг тухайн шатны ИТХ-д хэлэлцүүлэн батлуулахаар хүргүүлэхдээ тухайн орон нутгийн хөгжлийн хөтөлбөр төлөвлөгөөтэй хэрхэн уялдсан талаарх дэлгэрэнгүй тайлбар үндэслэл, иргэдийн хурлын санал тэдгээрийг тусгасан байдал гэсэн дэлгэрэнгүй мэдээллийг хавсаргана”

<sup>5</sup> “ОНХС-аар хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээ нь ..... орон нутгийн дунд хугацааны хөгжлийн бодлого төлөвлөлттэй уялдсан байх”

<sup>6</sup> “Баг, хорооны Засаг дарга ИНХ-д иргэдийн саналын урьчилсан жагсаалт, харья сум, дүүргийн ЗД-аас ирүүлсэн хөгжлийн бодлоготой уялдуулсан төслийн санал болон хурлын явцад иргэдээс гарсан саналыг нэг бүрчлэн хэлэлцэнэ”

Аймгийн ЗДТГ-аас 2016 онд аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний саналыг 15 сумаас урьдчилан бэлтгэсэн саналын хуудсаар авч, түүнийг нэгтгэн эрэмбэлж аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэн баталсан боловч Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар батлагдсан журмын 12 дугаар зүйлд заасны дагуу иргэний танхимаар нийтэд зар мэдээ хүргэсний үндсэн дээр нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулсан талаар хангалттай нотлох баримт байхгүй байна.

Аудитын явцад авсан судалгаагаар аймгийн хэмжээнд 18-с дээш насын 54710 хүн байгаагаас 11,5 хувь буюу 6315 иргэнээс ОНХС-гийн хөрөнгийг зарцуулах санал авсан ба үүнээс Жинст сум 52,9 хувь буюу 704 хүн санал өгсөн нь хамгийн их, Бууцагаан сумын хувьд 1,7 хувь буюу 39 иргэн санал өгсөн нь хамгийн бага хувьтай байна.

Аудитын явцад иргэдээс авсан санал асуулгаар ОНХС-гийн асуудлыг хэлэлцэх багийн ИНХ-д оролцдог уу гэсэн асуултад 19,8 хувь нь байнга, 38,4 хувь нь хааяа, 41,8 хувь нь үгүй гэж хариулсан, “ОНХС-аас ямар төсөл арга хэмжээ санхүүжүүлэх боломжтой тухай мэдээлэл болон таны саналыг авах хуудас танай өрхөд ирж байсан уу” гэсэн асуултанд нийт оролцогчийн 29,2 хувь нь мэдээлэл байнга ирдэг, 39,6 хувь нь саналын хуудас ирдэггүй ч хурал болох талаар мэдээлэл өгдөг, 31,3 хувь нь саналын хуудас ирдэггүй, мэдээлэл ч өгдөггүй гэж хариулснаас хараад цаашид Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар батлагдсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын 12.2.16<sup>7</sup> дэх заалтыг амьдралд хэрэгжүүлж, багийн ИНХ-д иргэдийн оролцоог нэмэгдүүлэх шаардлагатай байгааг харуулж байна.

Мөн тус санал асуулгаар хэрвээ та хуралд оролцож байсан бол зайлшгүй шаардлагатай асуудлыг иргэдээр хэлэлцүүлдэг үү гэсэн асуултад 65,9 хувь нь цаанаасаа бэлтгэсэн болон оролцогч иргэдээс санал авч дэвшүүлэн хэлэлцүүлдэг, 34,1 хувь нь иргэдийн саналыг бараг сонсдоггүй, нэр төдий хурал болдог гэж хариулт өгчээ.

Баянлиг, Баян-Өндөр, Бөмбөгөр, Бууцагаан, Баянбулаг, Эрдэнэцогт зэрэг сум ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг иргэдэд нээлттэй хэлэлцүүлж иргэдээс санал авч эрэмбэлсэн гэх боловч түүнийг нотлох баримтгүй, багийн ИНХ-ын тогтоол, хурлын тэмдэглэл бүрэн бус байгаа нь “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар--ын 4.2<sup>8</sup> дахь заалтыг зөрчсөн байна.

<sup>7</sup> “саналыг асуулгын хуудсаар авахад энэ журмын 1 дүгээр хавсралтад заасан маягтыг ашиглах ба маягтыг баг, хорооны айл өрх бүрт жил бүрийн 1 дүгээр улиралд багтаан хүргүүлнэ”

<sup>8</sup> “Тухайн орон нутгийн иргэдийн саналыг авч зохих журмын дагуу эрэмбэлэгдсэн байх”

Зарим сум иргэдийн санал аваагүй 88,2 сая төгрөгийн 11 төсөл, арга хэмжээг ИТХ-аар баталж санхүүжүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 60.3.4<sup>9</sup>, 60.3.6<sup>10</sup> дахь заалт, Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар батлагдсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын холбогдох заалтуудыг зөрчжээ. Тухайлбал:

*Аймгийн ОНХС-аас иргэдийн санал аваагүй атлаа төрийн үйлчилгээний нэгдсэн төвийн засвар, тооног төхөөрөмж авахад 20,0 сая, Эрдэнэцогт, Галуут сумдын багийн эмч нарыг унаажуулахад 18,0 сая төгрөгийг баталж санхүүжүүлсэн;*

*Баянхонгор сумын 8-р багийн ИНХ-аас усан сан барих санал гарваагүй байхад сумын ИТХ-аар баталж 7,9 сая төгрөгөөр санхүүжүүлж хэрэгжүүлсэн;*

*Баянговь сумын дөрвөн багийн иргэдийн нийтийн хурлаас ОНХС-ийн хөрөнгөөр 21 ажил хэрэгжүүлэхээр санал гаргасан байхад сумын ЗДТГ эдгээрийн оронд санал аваагүй 28,3 сая төгрөгийн 6 ажлыг ИТХ-д өргөн мэдүүлж батлуулсан;*

*Эрдэнэцогт сумын 2,3-р багийн ИНХ-аас малжуулах саналыг гаргасан байхад саналыг батлаагүй атлаа санал аваагүй 14,0 сая төгрөгийн 2 ажлыг ИТХ-аар баталсан байна.*

Баянговь сум ИТХ-ын хуралдаанаар батлаагүй байхад сумын Засаг дарга асан Б.Мөнхсайхан бүрэн эрхээ хэтрүүлж нутгийн дууны фонограмм хийлгэхэд 3,5 сая, 2012-2016 оны тайлангийн ном хэвлүүлэхэд 4,1 сая, утгах, үдэх хаалга хийлгэхэд 9,8 сая, илжиг, нохой устгахад 1,4 сая, наадмын зардалд 5,0 сая, наадмын талбайн их засварт 4,5 сая, нийт 28,3 сая төгрөг зарцуулсныг аймгийн Засаг даргын дэргэдэх СХААлба шалгаж, хуулийн байгууллагад шилжүүлж, санхүүгийн албаны дарга Б.Энхжаргалыг ажлаас чөлөөлөх арга хэмжээ авчээ.

### 2.3. ОНХС-ийн хөрөнгөөр зураг төсөөгүй төсөл арга хэмжээг баталж хэрэгжүүлсэн байна.

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний зураг, төсөв, өртгийн тооцоог урьдчилж гаргаагүй, зураг төсвийг гаргуулсан боловч өртгийн тооцоог эрх бүхий байгууллагаар хянуулж баталгаажуулаагүй нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4<sup>11</sup> дэх заалт, “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар-“ын 4.7<sup>12</sup> дахь заалттай нийцэхгүй байна. Тухайлбал:

<sup>9</sup> “Нийтийн эрх ашигт нийцээгүй үйл ажиллагаа”

<sup>10</sup> “ОНХС-ийн хөрөнгийг орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээнд зарцуулахыг хориглоно”

<sup>11</sup> “Хөрөнгө оруулалтын төсөвтэй техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана”

<sup>12</sup> “Хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээ нь хуульд заасны дагуу ТЭЗҮ хийгдсэн, зураг төсөв нь батлагдсан, байгаль орчинд нөлөөлөх үнэлгээ хийгдсэн, бусад зөвшөөрөлтэй байх”

Баянбулаг сум Сайрын амны худаг сэргээн засварлах 7,9 сая төгрөгийн ажлыг зураг төсөөгүй гүйцэтгэсэн ба худгийн барилгын ажлын гүйцэтгэлийг авсан санхүүжилттэй тулган шалгахад 1,8 сая төгрөгөөр дутуу байгаа тул гүйцэтгэгчээр төсөөт буцаан төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

Гурванбулаг сум 45,8 сая төгрөгийн Жи-мобайлын станцын барилга, 6,0 сая төгрөгийн усны харуулын байр, 17,8 сая төгрөгийн 4 дүгээр багийн төвийг шилжүүлэх ажлыг хийж гүйцэтгэхдээ зураг төсөө хийлгээгүй, хуучин цагдаагийн байрны барилгыг нийтийн аж ахуйн үйлчилгээ болгон засварлахаар 15,0 сая төгрөг төсөөт өртөг бүхий төсөө хийлгэсэн боловч гүйцэтгэгч ЦЭСДА ХХК нь магадлангаар оруулж баталгаажуулаагүй байна.

**2.4. Баянхонгор аймаг, Гурванбулаг, Бууцагаан сумын бусад сумд ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх ажлын гүйцэтгэгчийг хууль, журмын дагуу сонгон шалгаруулсан байна.**

Аймаг, сумын ИТХ-аар ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 332 хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд нийт 6500,5 сая төгрөг батлагдсанаас өмнөх оноос шилжиж ирсэн 66 ажилд 3104,7 сая, тухайн онд хэрэгжих 266 төсөл, арга хэмжээнд 3395,8 сая төгрөгийг зарцуулахаар хуваарилжээ.

2016 онд шинээр хийхээр төлөвлөсөн 266 төсөл, арга хэмжээнээс 530,7 сая төгрөгийн 40 төсөл арга хэмжээ хэрэгжээгүй бөгөөд хэрэгжүүлсэн 226 төсөл арга хэмжээнээс 10 ажилд нээлттэй тендер шалгаруулалт, 20 ажилд харьцуулалтын арга, 193 ажилд шууд гэрээ байгуулж, Засгийн газрын тогтоосон босго үнээс дээш үнийн бүхий 3 ажлыг худалдан авах ажиллагаа зохион байгуулалгүй шууд гэрээ байгуулсан зөрчил илэрлээ. Тухайлбал:

Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 21,3 сая төгрөгийн Баянхонгор сумын ногоон байгууламжийн услалтын системийн засвар үйлчилгээний ажил, Бууцагаан сум 19,5 сая, Гурванбулаг сум 13,7 сая төгрөгийн нарны цахилгаан эрчим хүчээр хангах төслийг шууд гэрээ байгуулж хэрэгжүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 24.4<sup>13</sup> дэх заалтыг зөрчсөн тул цаашид алдааг давтан гаргахгүй байх зөвлөмжийг хүргүүлэв.

Гурванбулаг сумын төслийг хэрэгжүүлэгч “Их түйн гол” ХХК нь гэрээний дагуу бараагаа хүлээлгэн өгөөгүй, тус бараа материалыг нэр төрлөөр нь бус

<sup>13</sup> “Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулаадаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно”

“Генератор цахилгаан үүсгэвэр” гэсэн нэрээр бүхэлд нь үнэлж падаан бичсэн нь хөрөнгө дутагдах, үрэгдэх эрсдэлийг дагуулж байна.

Аймгийн хэмжээнд 2016 онд гэрээ байгуулсан 292 ажлаас 4917,1 сая төгрөгийн 266 ажил бүрэн хэрэгжиж, 1052,7 сая төгрөгийн 26 ажил дутуу хэрэгжсэн бөгөөд тайлант онд төлөвлөсөн 530,7 сая төгрөгийн 40 ажил огт хэрэгжээгүй байна.

ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн ажлын сонгон шалгаруулалтыг хүснэгтээр харуулбал:

/ажлын тоогоор/

| №                | Аймаг, сумын нэр        | ИТХ-аар батлагдсан ХО, хөтөлбөр, төсөл арга хэмжээ | Гэрээ байгуулсан ХО, хөтөлбөр, төсөл арга хэмжээ | Бүрэн хэрэгжсэн ХО, хөтөлбөр, төсөл арга хэмжээ | Дутуу хэрэгжсэн ХО, хөтөлбөр, төсөл арга хэмжээ | Огт хэрэгжээгүй ХО, хөтөлбөр, төсөл арга хэмжээ |
|------------------|-------------------------|--|--|---|---|---|
| 1                | Баянхонгор аймгийн ОНХС | 36   | 36   | 34  | 2   | 0   |
| 2                | Баянхонгор сум          | 31   | 31   | 27  | 4   | 0   |
| 3                | Өлзийт                  | 18   | 18   | 15  | 3   |   |
| 4                | Жинист                  | 12   | 11   | 11  |   | 1   |
| 5                | Богд                    | 11   | 10   | 8   | 2   | 1   |
| 6                | Баянлиг                 | 13   | 11   | 11  | 0   | 2   |
| 7                | Баянговь                | 10   | 6  | 5   | 1   | 4   |
| 8                | Шинэжкинст              | 11   | 8  | 8   |   | 3   |
| 9                | Баянөндөр               | 11   | 11   | 8   | 3   | 0   |
| 10               | Баянцагаан              | 4  | 4  | 4   | 0   | 0   |
| 11               | Баацагаан               | 15   | 13   | 12  | 1   | 2   |
| 12               | Бөмбөгөр                | 18   | 15   | 15  | 0   | 3   |
| 13               | Бууцагаан               | 22   | 22   | 20  | 2   | 0   |
| 14               | Хүрээмараал             | 17   | 15   | 14  | 1   | 2   |
| 15               | Баянбулаг               | 15   | 13   | 13  |   | 2   |
| 16               | Гурванбулаг             | 23   | 14   | 12  | 2   | 9   |
| 17               | Заг                     | 10   | 9  | 8   | 1   | 1   |
| 18               | Жаргалант               | 14   | 12   | 11  | 1   | 2   |
| 19               | Галуут                  | 14   | 10   | 8   | 2   | 4   |
| 20               | Баяновоо                | 19   | 15   | 15  |   | 4   |
| 21               | Эрдэнэцогт              | 8  | 8  | 7   | 1   | 0   |
| Аймгийн нийт дүн |                         | 332  | 292  | 266   | 26  | 40  |

**2.5. Төсвийн байгууллагын урсгал зардлыг санхүүжүүлж ОНХС-ийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан байна.**

Өмнөх оны ОНХС-д хийсэн нийцлийн аудитаар ОНХС-аас 729,8 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан зөрчил илэрсэнд зөвлөмж өгсөн боловч зарим сум зөвлөмжийг хэрэгжүүлээгүйгээс 2016 онд ОНХС-ийн 44,8 сая төгрөгийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан зөрчил илэрлээ.

Баян-Овоо сум ЗДТГ-т 0,8 сая төгрөгийн эд хөрөнгө бэлтгэсэн, цагдаагийн байрны дулааны шугамын засварт Бөмбөгөр сум 3,2 сая, Бууцагаан сум 3,0 сая, Өлзийт 3-р багийн төв барихад 30,0 сая төгрөгийг тус тус зориулалт бусаар

зарцуулж Төсвийн тухай хуулийн 60.3.1<sup>14</sup> дэх “Орон нутгийн сангийн заавар”-ын заалтыг зөрчсөн тул цаашид алдааг давтан гаргахгүй байх зөвлөмжийг сумдын удирдлагуудад хүргүүлэв.

Бөмбөгөр сум ЗДТГ-т 1,3 сая төгрөгийн үнэ бүхий компьютер худалдан авсан, Жаргалант сумын “Үл хөдлөх хөрөнгийн цахим бүртгэл” төсөл арга хэмжээний интернетийн шугамын ажлыг гүйцэтгэхдээ “Мэдээлэл холбооны сүлжээ” ТӨК Баянхонгор аймгийн газар интернетийн урсгал зардалд 6,5 сая төгрөгийг урьдчилж авсан зөрчил илэрсэнд төлбөрийн акт тогтоов.

*2.6. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээг гэрээнд заасны дагуу хугацаанд нь хүлээлгэж өгөөгүй, захиалагчийн хяналтыг мэргэжлийн байгууллагаар хийлгээгүй байна.*

Аймгийн ОНХС-гийн хөрөнгөөр хийгдсэн төсөл, арга хэмжээний захиалагчийн хяналтыг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж, хууль журмын дагуу санхүүжилтийг олгосон байхад сумын ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэж буй төсөл, арга хэмжээнд захиалагчийн хяналтыг мэргэжлийн байгууллагаар хийлгээгүйгээс хөрөнгийн чанарт сөргөөр нөлөөлөх хандлагатай байна.

Сумын ОНХС-гийн хөрөнгөөр хийгдсэн төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд сумын Засаг даргын захирамжаар сумын ЗДТГ-ын ажилчдаас бүрдсэн комисс хяналтыг хэрэгжүүлсэн ч тэдгээрийн мэргэжлийн чадвар дутмаг, шаардлагатай тоног төхөөрөмж байхгүйгээс хяналт төдийлөн үр нөлөөтэй хэрэгжихгүй байна.

**Баянбулаг** сумын ОНХС-ийн хөрөнгөөр халуун усны барилгын ажлыг гүйцэтгүүлэхээр 78,6 сая төгрөгийн гэрээг 2013 онд “Элит харш” ХХК-тай байгуулсан боловч тус компани гэрээгээр хүлээсэн үүргээ 2017.04.10-ний байдлаар биелүүлээгүй, ЗДТГ-ын зүгээс захиалагчийн хяналт тавиагүй зөрчил илэрлээ. Иймд Иргэний хуулийн дагуу гэрээнд заасан хугацаанд нь ажлаа гүйцэтгэж хүлээлгэн өгөөгүй тус аж ахуйн нэгжийг хуулийн байгууллагад шилжүүлэн төсөвт учирсан хохирлыг нэхэмжлэх албан шаардлагыг сумын Засаг даргад хүргүүлэв.

**Гурванбулаг** сумын ОНХС-ийн хөрөнгөөр “Эх-Өлзийт богд” ХХК халуун усны харуулын байрыг 6,0 сая төгрөгөөр гүйцэтгэхдээ зөөврийн түр барилгыг суурь хийхгүйгээр байрлуулж, гэрээний үүргийг биелүүлээгүй тул гэрээний хавсралт зургийн дагуу гүйцэтгэгчээр суурь хийлгэх албан шаардлагыг хүргүүлэв.

<sup>14</sup> “ОНХС-ийн хөрөнгийг..орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргээс бусад хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулахыг хориглоно”

**Бууцагаан сум** 23,9 сая төгрөгийн гэрээтэй сумын худгийн засварын ажлыг “Монгол соёл буянт гол” хоршоо гүйцэтгэхдээ худгийн барилгын ханыг зураг төсвийн дагуу хийж гүйцэтгээгүй өөр материалаар барьсан зөрчилтэй тул зураг төсвийн дагуу хийж гүйцэтгэх албан шаардлагыг хүргүүлэв.

**Жаргалант** сумын ОНХС-ийн хөрөнгөөр “Баяншарбулаг” ХХК өвс тэжээлийн агуулах барих 23,9 сая төгрөгийн гэрээг 2014 онд байгуулан 19,6 сая төгрөгийн санхүүжилт авсан боловч ажлаа бүрэн дуусгаж хүлээлгэн өгөөгүй байна. Иймд Иргэний хуулийн дагуу гэрээт ажлаа хугацаанд нь гүйцэтгэж хүлээлгэн өгөөгүй тус аж ахуйн нэгжийг хуулийн байгууллагад шилжүүлэн төсөвт учирсан хохирлыг нэхэмжлэх албан шаардлагыг сумын Засаг даргад хүргүүллээ.

**Баян-Өндөр** суманд ОНХС-гийн хөрөнгөөр 2014-2016 онд “Сумын гудамж талбайг камержуулах” ажлыг гүйцэтгэгч “Навтгар хайрхан” ХХК ажлаа бүрэн хийсэн боловч хүлээлгэж өгөөгүй, Жимобайлын барилгын ажлыг гүйцэтгэгч Улаанбаатар хотын “Ас холдинг” ХХК 55,0 сая төгрөгийн санхүүжилт авсан бөгөөд олдохoo больсон, барилгын хаяавч дутуу, дээврийн ажил муу хийгдсэн, Улаанбаатар хотын “Гичгэнэ хяр” ХХК тус сумын цэцэрлэгт хүрээлэнгийн ажилд 52,1 сая төгрөгийн санхүүжилт авч, 2015.07.01-нд хүлээлгэн өгөх ёстой боловч ажил дутуу, хүүхдийн тоглоомын чанар муу хийгдсэн, одоо хүртэл ажлаа дуусгаж хүлээлгэж өгөөгүй байгаа тул дээрх 3 ажлыг бүрэн хийлгэж хүлээж авах талаар сумын Засаг даргад албан шаардлага хүргүүлэв.

**Баянхонгор сум** ОНХС-ийн хөрөнгөөр нэг бүр нь 7,9 сая төгрөгийн өртөг бүхий нийт 9 усан санг “БМБЖБ” ХХК шинээр барьж, “Жаргантайн хөх тариа ХХК” сумын 3,5-р багийн хуучин 2 худгийг сэргээн засварлаж, 2016 онд нийт 11 худгийг хүлээн авсан байхад одоогийн байдлаар 6 худаг ажиллаж байв. Иймд ашиглаагүй 37,9 сая төгрөгийн өртөг бүхий 5 худгийг 2017 оны 5 дугаар сард багтаан ашиглалтад оруулах албан шаардлагыг сумын Засаг даргад хүргүүлэв.

**Баянцагаан сумын** ОНХС-гийн хөрөнгөөр “Алтанзавьяа ундарга” ХХК сумын 0.4 квт-ын цахилгаан дамжуулах агаарын шугамын өргөтгөлийг гүйцэтгэсэн ба 950,0 мянган төгрөгийн хяналтын зардлыг суутган тооцолгүй гүйцэтгэгч компанийд олгосон зөрчилд төлбөрийн акт тогтоов.

**2.7. ОНХС-гийн хөрөнгөөр бий болсон 4101,0 сая төгрөгийн хөрөнгийг орлогод авч санхүүгийн тайланд тусгаагүй байна.**

2016 онд ОНХС-гийн хөрөнгө оруулалтаар өмнөх оноос шилжиж ирсэн болон тайланд онд нэмэгдсэн 5938,0 сая төгрөгийн хөрөнгийг холбогдох

байгууллагуудын санхүүгийн тайланд тусгасан боловч зарим сум хөрөнгийн эзэмшигчийн тогтоож, бүртгэлд тусгалгүй Няглан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4<sup>15</sup>, Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 8.6<sup>16</sup> дахь заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна. Тухайлбал:

*Баянхонгор аймаг “Гурван бүс цогцолбор”-т явган зам, авто машины зогсоол барих 80,0 сая, Баянхонгор сумын 3-р багийн “Багийн хөгжлийн төв”-ийг инженерийн шугам сүлжээнд холбох 135,0 сая, аймгийн төвийн гэр хорооллын 10 км хатуу хучилттай авто замын 3706,8 сая, цэвэр усны байгууламжийн хяналтын камер 28,6 сая, Галуут сумын багийн эмч нарыг унаажуулсан ба мотоциклийн үнэ 9,0 сая, нийт 3959,4 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэлд тусгаагүй;*

*Баянхонгор сум 2 хэсэг талбайд хийгдсэн 42,3 сая төгрөгийн хайс, ногоон байгууламжийг бүртгэлд дутуу тусгасан;*

*Жинст сум “Хаш өргөө” ХХК-ийн гүйцэтгэсэн 46.0 сая төгрөгийн өртөг бүхий багийн мэдээллийн төв, “Техник монде” ХХЗ-аас худалдан авсан 1,8 сая төгрөгийн багаж, хэрэгсэл, н.Буяндэлгэрээс худалдан авсан 275,0 мянган төгрөгийн тоглоом, эрдээлийн санд худалдан авсан 3374,8 мянган төгрөгийн өвс тэжээл, биеийн тамирын талбайн тохижилтод худалдан авсан 1466,1 мянган төгрөгийн сандал, нийт 52915,9 мянган төгрөгийн хөрөнгийг орлогод аваагүй;*

*Бөмбөгөр сум 29,0 сая төгрөгийн өртөг бүхий 2 гүний худаг, 2,0 сая төгрөгийн цэцэрлэгийн ногоон хүлэмжийг бүртгэлд тусгаагүй;*

*Гурванбулаг сум 4-р багийн төвийг шилжүүлэн, засварлаж барихад гарсан 17,8 сая төгрөгийн зардлыг капиталжуулаагүй;*

*Жаргалант сум ОНХС-ийн хөрөнгөөр бэлтгэсэн 2,0 сая төгрөгийн галын багаж, 0,6 сая төгрөгийн халдвэр хамгааллын хувцсыг тайланд тусгаагүй;*

*Баян-Өвөө сум 1,1 сая төгрөгийн үнэ бүхий камер, 0,8 сая төгрөгийн үнэ бүхий скайнериийг бүртгэл тайланд тусгаагүй байна.*

Дээрх дурдагдсан 19 нэр төрлийн 4107,9 сая төгрөгийн хөрөнгийг орлогод авахуулах албан шаардлагыг холбогдох албан тушаалтнуудад хүргүүлэв.

<sup>15</sup> “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, няглан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна”

<sup>16</sup> “ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтыг орон нутгийн өмчид бүртгэнэ”

ОНХС-гийн хөрөнгийн эх үүсвэрийг хууль, журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлж, хуваарилсан уу?

**Бүлэг 3. Сумдын ИТХ ОНХС-ийн зарцуулалтад хяналт тавих үүрэг бүхий Хяналтын хороог байгуулаагүй, ОНХС-гийн хэрэгжилтийн тайланг аймгийн ЗДТГ-т ирүүлээгүй байна.**

3.1. Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албанаас 2016 оны ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалтанд хяналт тавьж ажилласан хэдий ч сумдад ИТХ-ын дэргэдэх хяналтын хороо байгуулагдаагүй, сангийн үйл ажиллагаанд иргэд, иргэний нийгмийн байгууллагууд хяналт хийж оролцоогүй байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албанаас 2017 оны нэгдүгээр сард Орон нутгийн хөгжлийн сангийн 2016 оны хөрөнгийн зарцуулалтанд шалгалт хийж, дүнг Засаг даргын дэргэдэх Дотоод аудитын хорооны хурлаар хэлэлцүүлжээ.

Тус шалгалтаар 10 сумын ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалтад 380,3 сая төгрөгийн зөрчил илэрч, сангийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан 36,0 сая, худалдан авах ажиллагааны журам зөрчсөн 30,0 сая, гэрээний үүргээ биелүүлээгүй 30,0 сая, бусад зөрчилд 27,5 сая, нийт 123,5 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоосон тул нийцлийн аудитаар дээрх зөрчлүүдэд акт, албан шаардлагыг давхардуулаагүй болно.

2016 оны орон нутгийн сонгуулиар байгуулагдсан зарим сумын ИТХ нь төлөөлөгчдийг хороодод хуваарилсан боловч одоогоор хороод үйл ажиллагаа явуулж эхлээгүй байна. Тухайлбал: Эрдэнэцогт сумын ИТХ 2016.12.15-ны өдрийн хуралдаанаараа төлөөлөгчдийг дөрвөн Хороонд хуваарилсан боловч Л.Лутбат даргатай "Төсөв, санхүү, эдийн засгийн хороо" үйл ажиллагаа явуулж эхлээгүй байна.

Баянхонгор, Жаргалант, Бууцагаан, Хүрээмэарал зэрэг сумдаас бусад сумдад ИТХ-ын дэргэдэх хяналтын хороо байгуулагдаагүй ба 2016 оны ОНХС-гийн бүрдүүлэлт, хуваарилалт, зарцуулалтанд иргэд, иргэний нийгмийн байгууллагууд хяналт тавиагүй байна.

3.2. “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 10.1-д заасны дагуу тус аймгийн сумууд ОНХС-гийн хэрэгжилтийн тайланг хагас, бүтэн жилээр аймгийн ЗДТГ-ын хөгжлийн бодлогын хэлтэст ирүүлээгүй байна.

ОНХС-гийн хэрэгжилтийн тайланг “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 10.1<sup>17</sup>-ын дагуу хүргүүлээгүй, тайланд дүн шинжилгээ хийгээгүй байна. “2016 оны ОНХС-гийн тайлангаа үзүүл” гэхэд сумдууд “2016 оны худалдан авах ажиллагааны тайлан”-гаа үзүүлж байгаа ба ОНХС-гийн үйл ажиллагаатай холбоотой тусдаа тайлан бичдэггүй байна. Жинст сумын ИТХ 2016.12.15-нд хуралдаж “ОНХС-гийн хөрөнгөөр 2016 онд хэрэгжүүлсэн ажлын үр дүнд “Хангалттай” гэсэн үнэлгээ өгчээ.

**3.3. Сумдын ЗДТГ-ын санхүүгийн албанаас ОНХС-гийн хөрөнгөөр хийгдэж буй ажлын санхүүжилтийн мэдээллийг зааврын дагуу ард иргэдэд мэдээллийн самбар, шилэн дансаар ил тод мэдээлж, хурал дээр танилцуулсан байна.**

ОНХС-гийн хөрөнгөөр хийгдэж буй ажлын санхүүжилтийн мэдээллийг сумдууд “Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль”, “Төсвийн тухай хууль”, “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын дагуу ил тод мэдээлж, хурал дээр танилцуулж, иргэдийг мэдээлээр хангаж ажиллаж байна. Баянлиг сум төсөв, тусгай сангийн бүрдүүлэлт, хуваарилалт, зарцуулалтын талаар тарааж өгөх материал бэлтгэж, иргэдэд хүргүүлжээ.

**3.4. Сангийн сайдын 2014.03.06-ны өдрийн 43 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар” нь Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.3 дахь заалттай нийцэхгүй байна.**

Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 4.5<sup>18</sup> дахь заалт нь мөн зааврын 7.2.2, Төсвийн тухай хуулийн 58.2.3 дахь заалттай нийцэхгүй байна. Үүнээс шалтгаалж, сумын ИТХ-ын төлөөлөгч нар аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэж ажлыг сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж байна.

Энэ талаар Баянхонгор аймгийн Аудитын газрын 2015.05.08-ний өдрийн 41 тоот албан бичгээр УАГ-т санал хүргүүлсэн боловч албан ёсоор хариу ирүүлээгүй болно. Албан бичгийг хавсаргав.

**3.5. Өмнөх оны аудитаар тогтоосон актыг бүрэн барагдуулж, албан шаардлагыг 98,5 хувиар, зөвлөмжийг 76,4 хувиар биелүүлсэн байна.**

<sup>17</sup> “Сум, дүүргийн ОНХС-ийн хэрэгжилтийн явцын хагас жилийн тайланг жил бүрийн 7 дугаар сарын 10-ны дотор, бүтэн жилийн тайланг дараа оны 2 дугаар сарын 1-ны дотор аймгийн ЗДТГ-ын хөгжлийн бодлогын хэлтэст хүргүүлнэ....”

<sup>18</sup> “Орон нутгийн төсвийн бус байгууллагад ОНХС-аас хөрөнгө зарцуулахгүй байх”

ОНХС-гийн 2015 оны хөрөнгийн зарцуулалтанд хийсэн нийцлийн аудитаар нийт 2268,1 сая төгрөгийн төлбөр зөрчил илрүүлж, 261,2 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоосныг бүрэн барагдуулж, 1460,8 сая төгрөгийн зөрчил арилгах албан шаардлага өгсөнийг 2016 оны жилийн эцсийн байдлаар 98,5 хувиар биелүүлжээ.

“Шандаст хонгор” ХХК-д механикжсан салааны трактор нийлүүлэх ажлын 22,0 сая төгрөгийн санхүүжилтийг бүрэн шилжүүлсэн боловч уг тракторыг хүлээлгэж өгөөгүй байгаа тул энэ албан шаардлага биелээгүй ба аймгийн Засаг даргын дэргэдэх СХАА энэ зөрчилд төлбөрийн акт тогтоосон байна.

Өмнөх оны аудитаар сумдад өгсөн 5 заалт бүхий зөвлөмжийг Өлзийт, Богд, Шинэжинст Баянцагаан, Хүрээмарал сумаас бусад сумдууд бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Өмнөх онд аймгийн ОНХС-д хийсэн аудитаар 6 заалт бүхий зөвлөмжийг хүргүүлснээс “Аймгийн ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний урьдчилсан саналын жагсаалтыг иргэдээр нээлттэй хэлэлцүүлэх, “Скейл” ХХК-д урьдчилж олгосон 195,0 сая төгрөгийг буцаан төлүүлэх” зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Аудитаар нийт 4605,7 сая төгрөгийн төлбөр, зөрчил илрүүлж, 13,7 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 4395,3 сая төгрөгийн зөрчил арилгах албан шаардлага хүргүүлж, 194,7 сая төгрөгийн алдааг давтан гаргахгүй байх зөвлөмжийг хүргүүлэв.

## АУДИТЫН ДУГНЭЛТ

Нийцлийн аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг өгч байна.

1. ОНХС-ийн хөрөнгийг хууль, журамд заасан аргачлалын дагуу төлөвлөсөн байна.

2. ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө 18-аас дээш насны хүн амын 11,5 хувь буюу 6315 иргэнээс санал авсан, ОНХС-гийн асуудлыг хэлэлцэх багийн ИНХ-д санал асуулгад оролцсон иргэдийн 41,8 хувь нь “оролцдоггүй” гэж хариулснаас үзэхэд багийн ИНХ-д оролцох иргэдийн оролцоо хангалтгүй байна.

3. Багийн иргэдийн нийтийн хурлаар дэмжигдээгүй болон ТЭЗҮ, зураг төсөвгүй төсөл, арга хэмжээг баталж хэрэгжүүлсэн, худалдан авах ажиллагааны журмыг зөрчиж шууд гэрээ байгуулсан, төсвийн байгууллагын урсгал зардлыг санхүүжүүлж хууль, журмыг зөрчсөн байна.

4. Зарим сумдууд орон нутгийн тэргүүлэх чиглэлээ тодорхойлоогүй, урьдчилсан саналын жагсаалтыг бэлтгэж, саналыг хэлэлцүүлсэн гэх боловч нотлох баримтгүй байна.

5. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээнд тавих хяналтыг мэргэжлийн байгууллагаар хийлгээгүй, ашиглалтанд хүлээн авсан хөрөнгийг орлогоор бүртгээгүй байна.

6. Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албанаас 2016 оны ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалтанд хяналт тавьж ажилласан хэдий ч сумдад ИТХ-ын дэргэдэх хяналтын хороо байгууллагаагүй, сангийн үйл ажиллагаанд иргэд, иргэний нийгмийн байгууллагууд хяналт хийж оролцоогүй байна.

7. Өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Нийцлийн аудитын тайлантай танилцаж, Төрийн аудитын тухай хуулийн дагуу холбогдох саналаа 2017 оны 04 дүгээр сарын 27-ны дотор албан бичгээр Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.МӨНХБАТ

## АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

**2017.04.27**

**Баянхонгор сум**

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд:

### **Аймгийн ИТХ-ын дарга Ц.Отгонбаяр танаа**

1. Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 9.1 дэх заалтын дагуу ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэлийн явцад хяналт тавих Хяналтын хороог сумын ИТХ-ын дэргэд байгуулж ажиллуулах, тайланг ИТХ-аар хэлэлцэж, дүгнэлт өгч холбогдох шийдвэр гарган биелэлтийг тооцож байх.

### **Аймгийн Засаг дарга Г.Батжаргал танаа**

1. Аймгийн ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний урьдчилсан саналын жагсаалтыг хууль журмын дагуу боловсруулж, ажлын хэсэг байгуулж, баг, хорооны хурал, Иргэний танхимаар нээлттэй хэлэлцүүлж Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 6 дахь заалтыг хэрэгжүүлж ажиллах;

2. ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалтанд хийсэн өмнөх оны аудитаар илэрсэн зөрчлийг 2016 онд давтан гаргасан, аудитын зөвлөмжийг хэрэгжүүлээгүй сумдын Засаг дарга нарт арга зүйн зөвлөмж өгч ажиллах;

3. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжих төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг журмын дагуу сонгон шалгаруулах;

4. Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 10 дахь заалтын дагуу сумдаас тайланг авч хэлэлцэн, үр дүнг тооцож ажиллах.

5. Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор 2012-2015 онуудад ОНХС-аас олгосон зээлийн авлагыг барагдуулах талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнг улирал бүр тооцож ажиллах.

### **Аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга Ч.Мөнхцэцэг танаа**

1. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжиж, ашиглалтанд хүлээн авсан хөрөнгийн эзэмшигчийг аймгийн ИТХ-аар тогтоолгож, хөрөнгөд бүртгэсэн эсэхэд хяналт тавьж ажиллах.

## [Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалт]

УАГ-НАГ/2017/01-НА-БАГ-01

2. Ашиглалтад орсон төсөл, арга хэмжээний үр дүнг хянан үзэж, чанаргүй ажил гүйцэтгэсэн аж ахуйн нэгжүүдийг дахин худалдан авах ажиллагаанд оролцуулахгүй байх.

**Сумын ИТХ-ын дарга, Засаг дарга нарт**

1. Зардлыг хэмнэх замаар бий болсон эх үүсвэр болон ОНХС-ийн оны эхний үлдэгдэл, тайлант онд бий болсон эх үүсвэрийг сумын ИТХ-аар баталж байх;

2. Орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлийг тодорхойлж, багийн ИНХ-д оролцох иргэдийн оролцоог нэмэгдүүлж, эдгээртэй холбоотой баримт бичгийг холбогдох хууль, журмын дагуу баримтжуулах


3. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжих төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг журмын дагуу сонгон шалгаруулж, мэргэжлийн байгууллагаар захиалагчийн хяналтыг хийлгэж, Сангийн сайдын 2012 оны 290 дүгээр тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн журам”-ын 3.13, 3.19 дэх заалтуудыг хэрэгжүүлэх.

4. Сумын ИТХ-ын дэргэд хяналтын хороо байгуулж, Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 10.1 дэх заалтын дагуу тогтоосон хугацаанд ОНХС-ийн хэрэгжилтийн тайланг аймгийн ЗДТГ-ын ХОХБХэлтэст хүргүүлэх;

5. Сумын ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний урьдчилсан саналын жагсаалтыг хууль журмын дагуу боловсруулж, ажлын хэсэг байгуулж, багийн ИНХ болон Иргэний танхимаар нээлттэй хэлэлцүүлж Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 6 дахь заалтыг хэрэгжүүлж ажиллах;

6. ОНХС-ийн хөрөнгөөр иргэдээр дэмжигдээгүй, ТЭЗҮ, зураг төсөвгүй төсөл, арга хэмжээг баталдаг явдлыг зогсоож, сангийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулахгүй байх.

Нийцлийн аудитаар тогтоогдсон акт, албан шаардлагыг хугацаанд нь биелүүлж, өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, гарсан үр дүнгийн талаар 2017 оны 7 дугаар сарын 10-ны дотор аймгийн Төрийн аудитын газарт хариу ирүүлэх.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Б.МӨНХБАТ